

МАЛ ЭМНЭЛГИЙН ХҮРЭЭЛЭН, ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЛАБОРАТОРИЙН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭЛТ

Тус төслийн Монгол улсад үзүүлсэн үр өгөөжийн нэг нь Монгол улсын Мал эмнэлгийн салбарт Био-аюулгүй байдлын 3-р зэрэглэлийн иж бүрэн лаборатори байгуулан хүлээлгэн өгсөн бөгөөд тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.



Зураг 1. Мал эмнэлгийн хүрээлэнгийн Био-аюулгүй байдлын 3-р зэрэглэлийн лабораторийн нээлтэд Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Японы элчин сайд Игавахара Масару, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын суурин төлөөлөгч Шиничи Танака, ЭМЯ-ны НЭМБ-ын газрын дарга Д.Баярболд, МЭХ-ийн дарга Б.Батцэцэг, Төслийн удирдагч Т.Кимүра нар нээлтийн ажиллагаанд оролцов. 2024.04.30

Эрүүл мэндийн салбарт халдварт өвчний үүсгэгчийн геномын бүрэн дараалал тогтоох шинжилгээ хийх чадавх бүхий иж бүрэн лабораторийг ХӨСҮТ-ийн сүрьеэгийн лавлах лабораторид байгуулж дэвшилтэт тенологийг эмнэлгийн практикт нэвтрүүлэн ажиллаж техникийн туслалцаа үзүүлж байна.



Зураг 2. ХӨСҮТ-ийн сүрьеэгийн лавлах лабораторид геномын бүрэн дараалал тогтоох шинжилгээ хийх чадавх бүхий иж бүрэн лабораторийг байгуулав.